

**АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН
БАЙДАЛ**

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгийн шатрын холбоотой хамтран “ЦОДГОР ХҮҮ-2018” Аймгийн аварга шалгаруулах өсвөрийн шатарчдын тэмцээн 01 сарын 12–ны өдрүүдэд 5-р сургуулийн байранд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд аймгийн хэмжээний 5-н сургуулийн 80 тамирчин 4 насны ангилалаар өрсөлдөж, 1-р байранд орсон тамирчид 2018 оны өсвөрийн үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхтэй болсон.



Шатрын өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 02 сарын 24-нд 2-р сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 3 багийн 80 тамирчид оролцсон. Тэмцээнд амжилттай оролцож эхний байрт тамирчид Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээн эрхээ авлаа. Тэмцээнийн шагналын зардал болох 420000 төгрөгийг Аймгийн шатрын холбооноос гаргасан.



Аймгийн Биеийн Тамир Спортын Газар, “Сансар Хайрхан” клуб хамтран хүүхэд багачуудын дунд ширээний теннисний спортыг эрчимтэй хөгжүүлэн өсвөр үеийн шигшээ баг тамирчдыг шинээр бүрдүүлэх, аймгийн аварга тамирчдыг тодруулан, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилгын хүрээнд “Өсвөр Үеийн Аймгийн Аварга Шалгаруулах Тэмцээн”-ийг 2018 оны 03 сарын 11-ний өдөр Политехник коллежийн спорт зааланд амжилттай

зохион

байгууллага.Тэмцээнийг



нээлттэй

зохион

байгуулагдсан



Чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 03 сарын 9-нд Аймгийн биеийн тамир, спортын газрын зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд 3-н сургуулийн 80 гаруй тамирчид 13 жинд хурд хүч авхаалж самбааг сорин өрсөлдлөө. Шилдэг тамирчинаар М.Бүүвэйбаатар, М.Түмэнжаргал нар шалгарсан. Багийн дүнгээр 1-р байранд БТСГазар, 2-р байранд 2-р сургуулийн баг тамирчид оролцлоо.



Даамны өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 03 сарын 08-нд Политехник коллежийн спорт зааланд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 4 сургуулийн 60 тамирчид оролцсон. Тэмцээнд амжилттай оролцож эхний байрт тамирчид Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээн эрхээ авлаа.



Говьсүмбэр аймгийн өсвөрийн хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 04 сарын 29 ний өдөр зохион байгуулж явуулсан. Тус тэмцээнд Сүмбэр сумын 1-р, 2-р, 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургууль, Баянтал сумын 4-р сургуулийн нийт 100 гаруй тамирчид 42 багц медалийн төлөө өрсөлдлөө. Тэмцээнд түрүүлсэн тамирчид Хэнтий аймаг болох улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.



Орчин цагийн зэвсэгт хүчний 97 жилийн ойг угтан “Кросс” гүйлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 03 сарын 10-нд аймгийн “SUMBER GARDAN” цэцэгт хүрээлэнд зохион байгуулагдлаа. Энэхүү тэмцээнд 6 байгууллагын 60 гаруй тамирчид 4 насны ангилалд хурд хүч авхаалж самбааг сорин өрсөлдлөө. Мөн Дорноговь аймгийн айраг сумын онцгой байдлын газрын 2 тамирчин ирж оролцсон.



Аймгийн даамны холбоотой хамтран 2018 оны насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 04 сарын 28-нд Чөлөөт бөхийн танхимд амжилттай зохион байгуулж, нийт 26 тамирчин оролцсон.

Эрэгтэй

- 1-р байранд Д.Гарамдорж-Өндөр настан
- 2-р байранд Ё.Бат-Өлзий –Аймгийн шүүх
- 3-р байранд Ц.Түмэнбаяр-Шивээ-Овоо ХК

Эмэгтэй

- 1-р байранд Ц.Сарантуяа – 2 сургуулийн сурагч
- 2-р байранд Ц.Мөнхжин- 3-р сургуулийн сурагч
- 3-р байранд П.Байгальмаа- 5-р сургуулийн багш



Чөлөөт бөхийн олон хотын өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04 сарын 23-28-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд ОХУ, Буриад, Өвөрмонгол, Монголын нийт 50 багийн 600 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас Ш.Наранбаяр дасгалжуулагчтай 15 тамирчин оролцож, хөвгүүдийн +85кг жинд Ө.Бумба-Очир хүрэл медаль хүртсэн.



Дорноговь аймгийн Жүдо бөхийн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 03 сарын 16,17-ны өдрүүдэд Сайншанд хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 8 байгууллагын тамирчид 100 гаруй тамирчид 13 жинд өрсөлдлөө. Говьсүмбэр аймгийн баг тамирчид дараах амжилтыг үзүүллээ.

хөвгүүд: 27кг жинд М.Идэрбаатар мөнгөн медаль, 34кг жинд Б.Билгүүнтулга хүрэл медаль, 38кг жинд Ц.Алтангэрэл хүрэл медаль, 50кг Б.Ууганбаяр алтан медаль,

охид: 32кг жинд Н.Баясгалан мөнгөн медаль, Б:Маралмаа, А.Анар нар хүрэл медаль, +63 жинд М.Мөнгөнцэцэг алтан медаль, Б.Цоож хүрэл медаль хүртэж, өагийн дүнгээр 3-р байранд орлоо.

онгол улсын жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олгох Зүүн бүсийн жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 04 сарын 01-нд Хэнтий аймгийн Биеийн тамир, спортын зааланд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 5 аймгийн 300 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд Говьсүмбэр аймгийн 2 дасгалжуулагч 20 тамирчин хамт оролцсон.

Хөвгүүд:

30кг жинд Д.Эрдэнэбат алтан медаль-Хаялага спорт клубын тамирчин
-50 кг жинд Б.Ууганбаяр хүрэл медаль –Биеийн тамир, спортын газрын тамирчин
+50кг жинд О.Пүрэвбаатар алтан медаль–Биеийн тамир, спортын газрын тамирчин
Б.Есүхэй хүрэл медаль - Биеийн тамир, спортын газрын тамирчин

Охид:

-40кг жинд Марал-Эрдэнэ хүрэл медаль-Хаялага спорт клубын тамирчин
-44 кг жинд Гийгүүлэн хүрэл медаль – Хаялага спорт клубын тамирчин
-48кг жинд Уугансүвд хүрэл медаль– Хаялага спорт клубын тамирчин
Э.Энхжаргал хүрэл медаль - Биеийн тамир, спортын газрын тамирчин
-57кг жинд Билгүүнмөрөн алтан медаль– Хаялага спорт клубын тамирчин
-63кг жинд М.Мөнгөнцэцэг алтан медаль– Биеийн тамир, спортын газрын тамирчин
+70кг жинд Г.Цоож мөнгөн медаль медаль– Биеийн тамир, спортын газрын тамирчин
Нийт 4 алт, 1 мөнгөн, 6 хүрэл медаль хүртлээ. Хүрэл медалийн төлөө 3 тамирчин барилдаж, улсын аварга шалгаруулар тэмцээн нийт 16 тамирчин оролцох эрхээ авлаа.Шилдэг тамирчинаар Д.Эрдэнэбат шалгарсан

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦСОН БАЙДАЛ

Боксын 2018 оны өсвөрийн үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 01-7-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 27 байгууллагын 202 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд Шивээ-Овоо ХК-ны дэргэдэх Хаялага спорт клубын баг тамирчид амжилттай оролцож 44кг жинд Г.Ганчимэг, 50кг жинд А.Үүрцайх нар хүрэл медаль хүртсэн байна.



Тус тэмцээнд Б.Баттогтох дасгалжуулагчтай охидын “Говьсүмбэр Петротрак” багийн тамирчид мөнгөн медаль хүртлээ. Тус тэмцээний охидын гарааны шилдэг 5 тоглогчоор тамирчин Ч.Цэцэгчимэг, Э.Энхбуян, шилдэг дасгалжуулагчаар Б.Баттогтох багш шалгарсан.



МҮСБХ-ноос зохион байгуулсан Отгонтэнгэр Их Сургуулийн нэрэмжит ЕБС-иудын дундах U18 насны УАШТ-ээс Б.Баттогтох дасгалжуулагчтай Б.Батхишиг ахлагчтай хөвгүүдийн багийн тамирчид хүрэл медаль хүртсэн. Тэмцээнд нийт 33 багийн 300 тамирчид оролцон өрсөлдөж, Б.Баттогтох дасгалжуулагч багийн тамирчид хүрэл медаль

хүртлээ. Б.Баттогтох багш шилдэг дасгалжуулагчаар, гарааны шилдэг 5 тоглогч, шилдэг хамгаалагчаар тамирчин Ц.Баторгил тус тус шалгарлаа.

Тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлсэн аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, иргэн Л.Цэгээний гэр бүлд талархал илэрхийлье.



Сүмбэр сумын харьяат аймгийн арслан Баточирын ГОНЧИГТАВХАЙ чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн 2018 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд Аймгийн арслан Б.Гончигтавхай 125 кг жинд Цастын барс клубээс оролцож хүрэл медаль хүртсэн.



Тус тэмцээнд Говьсүмбэр аймгаас 8 тамирчин, дасгалжуулагчийн хамт оролцож, тамирчид 4 төрөл 16 зайд уралдсанаас О.Элбэрэл өврөөр даллах сэлэлтээр 1500метр, 400метрийн төрөлд тус бүрт хүрэл медаль, Э.Есүй-Эрдэнэ мэлхий сэлэлтээр 200метрийн төрөлд мөнгөн медаль хүртсэн амжилттайгаар тэмцээнийг өндөрлүүлсэн.



Монголын үндэсний сагсан бөмбөгийн холбооноос өсвөрийн 14 хүртэлх насны улсын аварга шалгаруулах тэмцээн нь 2018 оны 02 сарын 8-11 өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Тэмцээнд хот, хөдөөгийн эрэгтэй 26, эмэгтэй 10 баг оролцож аваргуудаа тодрууллаа. Говьсүмбэр аймгийн охид баг аваргын алтан медаль хүртсэн. Гарааний шилдэг 5 тоглогчийг тодруулахад шилдэг холбон тоглогчоор б.Цэцэгчимэг, шилдэг төвийн тоглогчоор б.Энхчимэг, шилдгийн шилдэг тоглогчоор Э.Энхбуян нар шалгарч, дасгалжуулагч Б:Баттогтох шилдэг дасгалжуулагчаар шалгарлаа.



Боксын 2018 оны залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн 03 сарын 03-11-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд 27 байгууллагын 200 гаруй тамирчид оролцсон. Тэмцээнд Шивээ-Овоо ХК-ны дэргэдэх Хаялага спорт клубын баг тамирчид амжилттай оролцож 48кг жинд Б.Нарангоо мөнгөн медаль хүртсэн байна.



RAW/CLASSIC Пауэрлифтингийн 3 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс Цагдаагийн хэлтсийн бөх, аймгийн арслан Дагвадоржийн ТҮМЭНЖАРГАЛ 3 алт, 1 мөнгө, Говьсүмбэр аймгийн уугуул өдгөө Strong клубт хичээллэж буй Нямдоржийн Амарбаясгалан 5 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ. Д.Түмэнжаргал Мастер-1 ангилалын -120 кг-ын жинд Штангтай суултын төрөлд 250 кг өргөж алт, Штангтай хэвтээ шахалтын төрөлд 152.5 кг өргөж мөнгө, Газраас шатанг татах төрөлд 270 кг газраас татаж алт, нийлбэр дүнгээр 672.5 кг өргөж алтан медаль хүртсэн байна. Н.Амарбаясгалан насанд хүрэгчдийн эрэгтэй ангилалын 59 кг-ын жинд Штангтай суултын төрөлд 160 кг өргөж хүрэл, нийлбэр дүнгээр 452.5 кг өргөж мөнгө, залуучуудын ангилалд 59 кг-ын жинд Газраас штанг татах төрөлд 170 кг газраас татаж мөнгө, Штангтай суултын төрөлд 155 кг өргөж мөнгө, Штангтай хэвтээ шахалтын төрөлд 122.5 кг өргөж мөнгө, нийлбэр дүнгээр 447.5 кг өргөж мөнгөн медаль хүртсэн амжилтуудыг үзүүлээ.



2018 оны 03 сарын 12-15-ны өдрүүдэд өсвөрийн 100 буудалт даамны улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас 10 тамирчин оролцлоо. Тэмцээний 64 буудалт даамны төрөлд Шивээговь сумын тамирчин Б.Батзориг алтан медаль авч, Азийн аварга шалгаруулар тэмцээнд оролцох эрх авсан. Мөн 17-19 насны ангилалд Л.Мөнхгэрэл 1-р зэрэг, 10-13 насны ангилалд Л.Мөнгөнсүвд 3-р зэрэг, А.Мөнгөнсарнай дэд мастерийн 2 балл авлаа.



Сэлэнгэ аймгийн Мандал сумын уугуул жудо бөхийн Олон Улсын хэмжээний мастер Г.Баатарсүрэнгийн нэрэмжит жудо бөхийн өсвөр үеийн 2018 оны Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 04 сарын 15-наас 04 сарын 18-ныг хүртэл Сүхбаатар хотноо амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд хот, хөдөөгийн 30 гаруй багийн 1050 тамирчин оролцлоо. Тэмцээнд Говьсүмбэр аймаг 2 дасгалжуулагч 15 тамирчин оролцсоноос 2004-дээш оны охидын -57кг жинд 3-р сургуулийн тамирчин Б.Билгүүнмөрөн хүрэл медаль хүртсэн.



Сагсан бөмбөгийн U12, U13 насны ангилалын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Б.Буянтогтох, Б.Баттогтох нарын удирдлага дор өсвөрийн баг тамирчид оролцлоо. U12 насны хөвгүүдийн ангилалд Б.Санчир ахлагчтай баг хүрэл медаль хүртэж, Б.Төгөлдөр "Шилдэг довтлогч"-оор шалгарсан байна.



Монголын сагсан бөмбөгийн холбооноос 4 дэх жилдээ зохион байгуулж буй “Мастерс лиг-2018” амжилттай болж Говьсүмбэр аймгаас төрөн гарсан сагсан бөмбөгийн анхны спортын мастер У.Мөнхбаатараар ахлуулан оролцсон манай аймгийн баг аваргаар тодорсон талаар өмнө мэдээлсэн билээ.





Билгийн тооллын ХҮИИ жарны “Тийн унжлагат” хэмээх ШОРООН НОХОЙ жилийн сар шинийн баярт зориулсан аймаг, сумын алдар цолтой хүчит бөхийн барилдааныг 2018 оны 02 сарын 10-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас зохион байгууллаа. Барилдаанд аймгийн арслан Д.Түмэнжаргал, Б.Гончигтавхай, С.Очирбат, Э.Мөнхбаатар, Б.Үүрцайх тэргүүтэй хүчит 32 бөх уран мэх, ухаан

бодол, бяр хүчийг үзэн барилдлаа.



Говьсүмбэр аймгийн 2018 оны аварга шалгаруулах үндэсний шагайн харваан тэмцээн 5-р сарын 13-ны өдөр БТСГ-ын зааланд амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд нийт 10 багийн 90 гаруй харваачид цэц мэргэнээ сорьсоноос:

Тэргүүн байранд Ж.Түвшинзаяа ахлагчтай Сүмбэр сумын баг

Дэд байранд аймгийн гоц мэргэн Н. Идэржавхлан ахлагчтай Сүмбэр сумын Чойр баг

Гутгаар байранд М. Ганбат ахлагчтай Шивээговь сумын багууд шалгарав.

Шагайн харвааны хүн нэг бүрийн цуваа харваанд:

Баянтал сумын харваач Улсын мэргэн М.Мөнхүү, Шивээговь сумын харваач С.Энх-Од нар

20-н сумнаас тус бүр 19 онож сум уралдаж Улсын мэргэн М.Мөнхүү түрүүлж С.Энх-Од

удаалж гутгаар байранд Шивээговь сумын харваач О.Ууганбаяр нар шалгарлаа.

Тэмцээнд оролцогчидоос хамгийн ахмад настай харваач нь Хүндэт харваач, аймгийн гоц

мэргэн Бадачин /83 нас/, хамгийн залуу харваач 12 настай н.Бат-Эрдэнэ нар байлаа.

Говьсүмбэр аймгийн үндэсний сурын холбоо Аймгийн нээлтийн харвааг 2018 оны 05 сарын 06-нд сурын талбайд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд аймгийн болон Шивээговь сумын нийт 15 харваачид оролцлоо.

Эрэгтэй цуваа харваанд

- 1-р байранд –Б.Батмөнх Аймгийн мэргэн, спортын мастер
- 2-р байранд Г.Батбаатар-залуу харваач
- 3-р байранд Ч.Сугармаа-Залуу харваач

Эмэгтэй харваанд

- 1-р байранд С.Туяагэрэл-Аймгийн мэргэн, спортын мастер
- 2-р байранд Ж.Норжмаа-Спортын мастер
- 3-р байранд С.Мөнхжаргал-залуу харваач

Хүүхдийн харваанд

- 1-р байранд Б.Баярбат- залуу харваач
- 2-р байранд Л.Отгонжаргал –залуу харваач
- 3-р байранд У.Отгонцэцэг-залуу харваач



Аймгийн хурц арслан Д.Рэнцэндорж агсны нэрэмжит өсвөрийн үндэсний бөхийн нээлттэй бүсийн тэмцээнийг 2018 оны 05 сарын 14-нд Биеийн тамир, спортын газрын спорт зааланд амжилттай зохион байгуулж, тэмцээнд 7 байгууллагын 70 гаруй тамирчид 5-н насны ангилалтай амжилттай оролцлоо.

7-8 насны ангилалд М.Түмэнжаргал алтан медаль- ГСА, А.Хос-Төгөлдөр мөнгө медаль- ГСА, М.Идэрбаатар хүрэл медаль-ГСА

9-10 насны ангилалд Өсөх-Ирээдүй алтан медаль- ДГА, Ч.Мишигдорж мөнгө медаль-ГСА, Есөнбаатар хүрэл медаль-Бор-Өндөр сум

11-12 насны ангилалд Ө.Шинэбаатар алтан медаль- ГСА, Цолмонбаяр мөнгө медаль- Бор-Өндөр сум , Энхбаяр хүрэл медаль-ДГА,

13-14 насны ангилалд Сайханбаяр алтан медаль- ДГАймгийн Айраг сум, О.Эрдэнэбилэг мөнгө медаль-ГСА , Х.Ган-Эрдэнэ хүрэл медаль-ГСА,

15-17 насны ангилалд Ө.Бум-Очир алтан медаль- ГСА, Анхбаяр мөнгө медаль-ДГА , Өлзий-Хутаг хүрэл медаль-ДГА,

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Шри Чинмойн маранфоны баг, Монголын хэт холын марафон гүйлтийн холбооноос Шри Чинмойн 12-24 цагийн гүйлтийн залуучууд, ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 08 сарын 04-05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Тэмцээнд аймаг, дүүрэг, спорт хороод, клубуудын 35 байгууллагын 108 тамирчин 3 насны ангилалд өрсөлдөж аваргуудаа тодрууллаа.



Монгол Улсын спортын мастер Д.Баточирын нэрэмжит 2018 оны 08 сарын 15-нд Улаанбаатар хотноо хөнгөн атлетикийн мастеруудын холбооны цомын тэмцээнд аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 37-р ангийн аврагч-гал сөнөөгч, ахлах ахлагч, Хөнгөн атлетикийн ОУХМ Д.Ариунжаргал амжилттай оролцож 100 м-ийн зай, 1500 м-ийн зайд тус бүр алтан медаль хүртлээ.



Засгийн 2017 оны 269 дугаар тогтоолын хүрээнд Үндэсний спортын VI их наадамд Говьсүмбэр аймгийн анхан шатны тэмцээнээс шалгарсан спортын 6 төрлийн 40 гаруй тамирчид амжилттай оролцож 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ. Наадмаас үндэсний бөхийн аймгийн цолтнуудын ангилалд аймгийн арслан Э.Мөнхбаатар мөнгөн медаль, нийтийн монгол бөхийн ангилалд Н.Пүрэвдаваа 5-р байр, Үндэсний сурын хана харваанд 1-р сургуулийн нийгмийн ажилтан Х.Мөнхзолбоо 20 сумандаа 20 онож хүрэл медаль, нийт 34 оноогоор “Спортын мастер” цолны болзол хангасан бол Онцгой байдлын газрын жолооч залуу харваач Г.Батбаатар 30 оноогоор “Спортын дэд мастер” цолны болзол хангалаа. Орон үндэсний сурын харвааны спортын хөгжүүлэх, оруулсан хувь нэмрийн үнэлж Онцгой байдлын газрын харваач спортын мастер Б.Цэрэнэдашийг БСШУС-ын яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсан.

Наадмын зардалд БСШУС-ын яамнаас унаанд зардал-1130,0 мян төгрөг, Аймгийн ЗДТГ-аас 1528,0 мян төгрөг, ОНХСангаас 1053,0 мян төгрөг, байгууллагаас 800,0 мян төгрөг, нийт 4511,0 мян төгрөгийг зарцуулсан.





Төв аймгийн зуун мод хотод 2018 оны 09 сарын 15-ны өдөр зохиогдсон өсвөрийн кросс уралдааны гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 16-17 насны хөвгүүд 4000м зайд Говьсүмбэр аймгийн тамирчин П.Төгөлдөр хүрэл медаль хүртлээ.



Монголын Үндэсний сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулсан сагсан бөмбөгийн насанд хүрэгчдийн В ангилалын 2018 оны улсын аварга шалгаруулах тэмцээнээс Б.Баттогтох дасгалжуулагчтай, Д.Номин ахлагчтай оролцсон эмэгтэйчүүдийн баг хүрэл медаль хүртлээ. Мөн гарааны шилдэг тоглогчдыг шалгаруулахад манай багийн Д.Номин шилдэг довтлон тоглогчоор, Б.Цасчимэг шилдэг төвийн тоглогчоор шалгарсан байна. Тэмцээний зардалд аймгийн Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрөөс 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ.



“СУПЕР-8” Идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээн 10 сарын 7-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр аймгийн өсвөрийн шигшээ багийн хөвгүүд, охид баг тамирчидтай амжилттай оролцлоо.

Эрэгтэй хүрэл медалийг Ч.Баясгалан менежертэй, СМ Б.Баярмаа дасгалжуулагчтай, Б.Даринчулуун дасгалжуулагчтай н.Содхүү ахлагчтай Говьсүмбэр Эрчим, Эмэгтэй алтан медалийг Ч.Баясгалан менежертэй, СМ Б.Баярмаа дасгалжуулагчтай, Б.Даринчулуун дасгалжуулагчтай н.Алтанзул ахлагчтай Говьсүмбэр Эрчим Тэмцээний Шилдэг хамгаалагч н.Баяндэлгэр Шилдэг довтлогч Б.Мөнхсайхан, Шилдэг дасгалжуулагч Б.Баярмаа шалгарсан.



2018 оны 10 сарын 28 - 11 сарын 2 хооронд Дундговь аймагт зохион байгуулагдсан 15-16 насны Өсвөр үеийн УАШТ-нд СМ Б.Баярмаа, СМ Б.Жамбаноров дасгалжуулагчтай Молор-Эрдэнэ ахлагчтай эрэгтэй баг 37 багаас 5-8 байр. Болор ахлагчтай эмэгтэй шигшээ баг 40 багаас 2-р байранд орж Мөнгөн медаль хүртлээ. Эмэгтэй багуудаас ШИЛДЭГ ХАМГААЛАГЧААР Ц.Бэрцэцэг шалгарлаа



С



